**БАТЛАВ.**
**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА Х.ХЭРЛЭН**

# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2018 оны 03 дугаар сарын 01-ний өдөр — Улаанбаатар хот

| Д/д | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин үр дүн | Төсөв | Үндсэн хэрэгжүүлэгч нэгж | Хамтран хэрэгжүүлэгч нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.** | 4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх; | Ажлын байранд тавих шалгуур үзүүлэлтийг мэргэжил, мэргэжсэн байдал, ажлын туршлага, ур чадвар зэрэгт тулгуурлан шинэчлэн боловсруулах, батлуулах, цаашдын үйл ажиллагаанд мөрдлөгө болгох; | 2018 он | Ажил гүйцэтгэх өндөр чадвартай мэргэжилтэй, мэргэшсэн, ажлын туршлага, ур чадвартай ажилтнууд тус газарт ажиллах боломж бүрдэнэ. | 500.000 төг | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | Хууль, эрх зүйн хэлтэс |
| **2.** | 4.1.2.2. Тусгай зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх; | Тусгай зөвшөөрөлд орж буй өөрчлөлт, хөдөлгөөнийг тухай бүрд нь олон нийт, төрийн бус байгууллагад ил тод нээлттэй болгож байгууллагын веб сайтад байршуулах | 2018 он | Тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн шуурхай ил тод, хяналттай болно. | | Кадастрын хэлтэс | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс |
| | | Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийнхөө файлд хяналт тавих боломжийг бүрдүүлсэн программ хөгжүүлэх | 2018 он – 2019 он | Төрийн үйлчилгээ, хяналт, ил тод болно. | 80.000.000 төг | | |
| **3.** | 4.1.2.5. Төрийн үйлчилгээний | Байгууллагын албан | 2018 он | Судалгаа хийж, | | Төрийн | Хяналт- |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шударга ил тод, нээлттэй байдлын талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа байнга ашиглах; | хаагчдаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид үзүүлж буй үйлчилгээний шударга ил тод, нээлттэй байдлын талаарх судалгаа хийх; | | санал боловсруулах, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах ажлыг хэвшүүлнэ. | | захиргааны удирдлагын хэлтэс | шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс |
| 4. | 4.1.2.6. Өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх; | Байгууллагын албан ёсны цахим хаягаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авах журмыг боловсруулж мөрдүүлэх; | 2018 он – 2019 он | Цахим хэлбэрээр өргөдөл, гомдол хүлээн авдаг болно. | | Хууль, эрх зүй хэлтэс | |
| | | Цахим хэлбэрээр гомдол хүлээн авах, явц, шийдвэрлэлтийн талаар хянах боломж бүхий программ хангамжийг хөгжүүлэх; | 2018 он – 2019 он | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хяналт боловсронгуй болно. | 20.000.000 төг | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | |
| 5. | 4.1.4.1. Тендерийн үйл ажиллагаа цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх; | Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг боловсронгуй болгох; | 2018 он | Эрх зүйн орчин боловсронгуй болно. | | Кадастрын хэлтэс | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс |
| | | Сонгон шалгаруулалттай холбоотой гомдол, хүсэлтийг нээлттэй ил тод болгох, цахим хуудсанд байршуулах; | 2018 он | Шийдвэрлэлт ил тод, шуурхай болно. | | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс |
| 6. | 4.1.6.1. Хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих; | Салбарын төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн авлигын эсрэг үйл ажиллагааг дэмжих; | 2018 он | Хүнд суртал, ашиг сонирхолын зөрчил арилна. | | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | |
| 7. | 4.1.6.5. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах; | Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийн ил тод болгох; | 2018 он | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэрээнүүдийг ил тод болгон ажиллаж хэвшинэ. | | Хууль, эрх зүйн хэлтэс | Холбогдох нэгж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын тайлан, төлөвлөгөөг цахимаар хүлээн авах ажлыг боловсронгуй болгох тавигдах шаардлагыг тодорхой болгох; | 2018 он – 2019 он | Хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай, хэмнэлт бий болно. | | Уул уурхайн, үйлдвэрлэл технологийн хэлтэс, Нүүрсний хэлтэс | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс |
| | | Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр төрийн болон бус байгууллагуудтай хамтран ажиллах; | 2018 он – 2019 он | Тусгай зөвшөөрөл бүхий талбайн нөхөн сэргээлт, хариуцлага сайжирч, хяналт нэмэгдэнэ. | | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | Холбогдох нэгж |
| | | Олон нийтийн дэд зөвлөлтэй хамтран ажиллах; | 2018 он | Хяналт, хариуцлага дээшилнэ. | | Бүх нэгж | |
| **8.** | 4.1.10.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах | Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон салбарын төрийн бус байгууллага, байгууллагын албан хаагчдын дунд авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах; | 2018 он | Авлигын эсрэг үзэл бодол хэвшил болно. Авлигаас урьдчилан сэргийлэх ажил сайжирна. | | Хууль, эрх зүйн хэлтэс | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс |

**Танилцсан:**
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Дашпүрэв

**Боловсруулсан:**
Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан Б.Алтан-Очир